



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/дс/1

Улаанбаатар хот

2 дугаар хорооны орон сууцны
байрнуудын орц засварын ажилд хяналт тавих
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй 2 дугаар хорооны орон сууцны байрнуудын орц засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын,
Тохижилт, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

Гишүүд: Б.Батзориг

2 дугаар хорооны Засаг дарга

З.Нармандах

Их Хангай СӨХ-ны захирал

С.Ариунжаргал

2 дугаар хорооны хэсгийн ахлагч

П.Эрдэнэсайхан

2 дугаар хорооны хэсгийн ахлагч

Д.Бурмаа

2 дугаар хорооны хэсгийн ахлагч

Нарийн бичгийн

дарга: Б.Батхуяг

Тохижилт худалдаа үйлчилгээний
хэлтсийн Дэд бүтэц, тохижилт, орчны
бохирдол хариуцсан мэргэжилтэн

2. Хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулж 14 хоног тутамд эргэн танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД